



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/243

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Жагсаалт батлаж, эрх шилжүүлэх тухай" А/373 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/373 дугаар тушаалаар батлагдсан "Сургуулийн спорт заалны барилгын их засвар /Хэнтий, Галшар сум/" барилгын их засварын ажлын худалдан авах ажиллагааны захиалагчийн эрхийг Галшар сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн ажлын худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, ашиглалтад хүлээлгэн өгөх хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Галшар сумын Засаг даргад даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

4. Эрх шилжүүлсэн ажлын захиалагчийн хяналтыг Галшар сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/-т хариуцуулсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА